# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 24 өдөр Дугаар А/243 Сүхбаатар сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, 13.2.10, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугээр зүйлийн 7.1.4, 7.1.5, 7.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөө сумын иргэн "Өгөөж баян" нөхөрлөлийн ахлагч С.Нэргүйгээс ирүүлсэн тус сумын "Могойн ам" гэх газар хууль бусаар газар ухаж байгаа тухай өргөдлийг газар дээр нь шалгаж, судлан дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Баттөвшин -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Гишүүд:

Б.Саруултөгс -Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

А.Ундраа -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Л.Уранчимэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Н.Оюун-Эрдэнэ -Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн

430810585

2. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиж, ажиллан дүгнэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 7-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Баттүвшин/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ц.РЭГЗЭДМАА